

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ЗАРИМ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН АЙМАГТАЙ БАЙГУУЛСАН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ОРОН НУТГИЙН АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН БАТАЛГААТАЙ
ХОЛБООТОЙ ЗААЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ӨМА-2024/31-2-ШТА-НА

КОМПАНИУДЫН АЙМАГТАЙ БАЙГУУЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭДЭГГҮЙ БАЙНА.

Даланзадгад хот 2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Аудитор М.Номиндарь

Утас: 70533552 Цахим хаяг: Nomindarim@audit.gov.mn

Аудитор Э.Жамцдорж

Утас: 70533552 Цахим хаяг: Jamtsdorje@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Дүрслэлийн жагсаалт.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	3
Ерөнхий мэдээлэл	4
БҮЛЭГ 1. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	5
1.1 Хамтын ажиллагааны гэрээнд бүх талын оролцоог хангаагүйгээс гэрээг хангалтгүй боловсруулсан байна	5
1.2 Зарим хамтын ажиллагааны гэрээг олон нийтэд мэдээлээгүй байна	6
БҮЛЭГ 2. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭЭГҮЙ НЬ ҮР ДҮНГ ТООЦОХ БОЛОМЖҮЙ БАЙНА	7
2.1 Хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнээгүй байна	7
2.2 Хамтын ажиллагааны хороо гэрээний биелэлтэд хяналт тавих үндсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна	9
ДҮГНЭЛТ.....	10
ЗӨВЛӨМЖ.....	11
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгийн газар
ХХК	Хариуцлагат хувьцаат компани

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Дүрслэл 1	Гэрээ байгуулсан тоо, хугацаа	4
Хүснэгт 1	Аудитад хамрагдсан компаниуд	5

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Өмнөговь аймгийн нутагт үйл ажиллагаа явуулдаг "Энержи ресурс" ХХК, "Мандал ресурс" ХХК, "Саус гоби сэндс" ХХК-ууд аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний орон нутгийн ажилтнуудын нийгмийн баталгаатай холбоотой заалтуудын хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хамтын ажиллагааны гэрээг хууль журамд нийцүүлэн боловсруулж, олон нийтэд мэдээлсэн эсэх?
- Хамтын ажиллагаанд тусгасан ажилтнуудын нийгмийн баталгаатай холбоотой заалтуудын хэрэгжилт үр дүнтэй эсэх?

Аудитын хамарсан хүрээ

Аймгийн ИТХ-ын захиалгаар Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулдаг "Энержи ресурс" ХХК, "Мандал ресурс" ХХК, "Саус гоби сэндс" ХХК-уудын аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд орон нутгийн ажилтнуудын нийгмийн баталгаатай холбоотой заалтуудын хэрэгжилтийг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг MNS6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталж, 2021 оны А/81 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилт, дэд зорилт, асуудлын шинжилгээнд хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав..

- Монгол Улсын үндсэн хууль
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Ашигт малтмалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын 2015 оны 430 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоол
- Байгуулсан хамтын ажиллагааны гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор М.Номиндарь, Э.Жамцдорж нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл:

Энержи Ресурс ХХК

Гэрээг нэг талаас Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, түүнийг төлөөлж аймгийн уул уурхай, ашигт малтмал, дэд бүтэц, байгаль орчны асуудал хариуцсан Засаг даргын орлогч С.Мөнхбаяр, нөгөө талаас 30 жилийн хугацаатай олгосон MV-011952 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Энержи ресурс ХХК-ыг төлөөлж Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч Ц.Баасандорж нар харилцан тохиролцож 2017 оны 06 сарын 22-ны өдөр гэрээг байгуулсан. Хийгдэх ажлын жагсаалтыг 4 жил тутамд баталж хэрэгжүүлэх ба тусгай зөвшөөрөл дуусгавар болсон эсхүл цуцлагдсан тохиолдолд тухайн гэрээг хугацаанаас өмнө цуцалсанд тооцно гэж гэрээнд заажээ.

Саус Гоби Сэндс ХХК

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 430, 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан гэрээний загварыг үндэслэн нэг талаас Өмнөговь аймгийг төлөөлж, аймгийн засаг дарга Р.Сэддорж, Өмнөговь аймгийн Гурвантэс сумыг төлөөлж Засаг дарга Г.Гангамаа, нөгөө талаас “Саус Гоби Сэндс” ХХК түүнийг төлөөлж Уурхайн орлогч дарга А.Баянбулаг нар харилцан тохиролцож 2022 оны 07-р сарын 24-ны өдөр гэрээг байгуулсан. Гэрээний хүчинтэй хугацаа 4 жил байна.

Мандал Ресурс ХХК

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 430, 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан гэрээний загварыг үндэслэн нэг талаас Өмнөговь аймгийг төлөөлж, аймгийн Засаг дарга Р.Сэддорж, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумыг төлөөлж Засаг дарга Э.Мөнхбаяр, нөгөө талаас “Мандал Ресурс” ХХК, түүнийг төлөөлж Үйл ажиллагаа хариуцсан захирал Б.Хангай нар нь харилцан тохиролцож 2023 оны 12 сарын 22-ны өдөр гэрээг байгуулсан. Гэрээний хүчинтэй хугацаа 2 жил байна.

Дүрслэл 1 Гэрээ байгуулсан тоо, хугацаа

Өмнөговь аймагтай 2016 оноос хойш байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”



БҮЛЭГ 1. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1. Хамтын ажиллагааны гэрээнд бүх талын оролцоог хангаагүйгээс гэрээг хангалтгүй боловсруулсан байна.

1.1 Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхайг ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана” гэж заасан байна.

1.2 Монгол Улсын ЗГ-ын 2016 оны 179 дүгээр тогтоолоор "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-ны загварыг баталсан байна.

1.3 Аймгийн Засаг дарга Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч "Энержи ресурс" ХХК, "Мандал ресурс" ХХК, "Саусгоби сэнд" ХХК-уудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 1 Аудитад хамрагдсан компаниуд:

№	Компаний нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний хүчинтэй хугацаа /жилээр/	Тусгай зөвшөөрөл эзэмшдэг газар
1	Энержи ресурс ХХК	2017.06.22	19	Цогтцэций сум
2	Мандал ресурс ХХК	2023.12.22	2	Мандал-Овоо сум
3	Саус гоби сэндс ХХК	2022.07.24	4	Гурвантэс сум

Эх сурвалж: Хамтын ажиллагааны гэрээнүүд

1.4 Компаниудтай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээ нь харилцан адилгүй загвартай байна. Тухайлбал “Энержи ресурс” ХХК, “Мандал ресурс” ХХК-уудтай байгуулсан гэрээнд тухайн сумын удирдлагын оролцоог хангаагүй, “Мандал ресурс” ХХК-тай байгуулсан гэрээнд хамтын ажиллагааны хороо байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой заалт тусгаагүй, мөн гэрээний хүчинтэй хугацаанууд харилцан адилгүй баталсан байна.

1.5 Аймгийн ИТХ-ын 2016 оны 06 сарын 10-ны өдрийн 89 дүгээр тогтоолд "Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн үндсэн болон туслан гүйцэтгэгч компаниудад ажиллаж байгаа нийт ажилчдын 50 хувиас доошгүй хувийг орон нутгийн орон нутагт 3-аас доошгүй жил амьдарч байгаа иргэд, иргэн байхаар" заасан байна.

1.6 Гэвч Саус гоби сэндс ХХК-тай байгуулсан гэрээний 4.4.1-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийт ажилтны 30 хүртэлх хувьд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах бодлогыг баримтлан ажиллана”, “Мандал ресурс” ХХК-тай байгуулсан гэрээний 4.5.1-т “Жилд 1 удаа “Нээлттэй хаалганы өдөр”, “Ажил мэргэжил сурталчлах өдөрлөг” зохион байгуулж Өмнөговь аймгаас нийт ажилчдын 10%-с доошгүй хувийг бүрдүүлэхээр эрмэлзэж ажиллана” гэж ИТХ-ын тогтоолд заасан хувь хэмжээг бууруулж гэрээнд тусгасан зөрчил илэрсэн.

1.7 Эдгээр нь гэрээ байгуулахдаа холбогдох бүх албан тушаалтны оролцоог хангаагүй, тогтоол шийдвэрийг бүрэн судлаагүй байгаа зэргээс шалтгаалсан байна. Иймд дээрх 3

компаниудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнүүдийг ЗГ-ын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан гэрээний загвар болон аймгийн ИТХ-ын 2016 оны 89 дүгээр тогтоолтой тус тус нийцүүлэн боловсруулж байгуулах зөвлөмж өглөө.

1.2 Зарим хамтын ажиллагааны гэрээг олон нийтэд мэдээлээгүй байна.

1.8 "Энержи ресурс" ХХК, "Мандал ресурс" ХХК, "Саус гоби сэндс" ХХК-уудын аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээг олон нийтэд мэдээлэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр заасан байна. Үүнд:

- Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор цахим хуудсанд байршуулах,
- Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага,
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөл.

1.9 Аймгийн цахим хуудас болох <http://www.omnogovi.gov.mn/> сайтад "Энержи ресурс" ХХК-тай байгуулсан гэрээг байршуулсан бол "Мандал ресурс" ХХК, "Саус гоби сэндс" ХХК-уудтай байгуулсан гэрээг мэдээлээгүй байна.

1.10 Мөн гэрээг Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлсэн эсэх нь нотлогдохгүй байна.

1.11 Энэ нь гэрээг байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилготой байгуулсан "Хамтын ажиллагааны хороо"-ны ажил хангалттай хийгдэхгүй байгаагаас шалтгаалж байна. Иймд хамтын ажиллагааны хороонд гишүүнээр орсон орон нутгийн төрийн байгууллагын төлөөлүүд хариуцлагатай ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭЭГҮЙ НЬ ҮР ДҮНГ ТООЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

2.1. Хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнээгүй байна.

2.1. Аудитад хамруулсан "Энержи ресурс" ХХК, "Мандал ресурс" ХХК, "Саус гоби сэндс" ХХК-уудын аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнүүдэд хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлийг харилцан адилгүй тусгасан байна. Үүнд:

Мандал ресурс ХХК-тай байгуулсан гэрээнд:

3.4.1. Компанийн захиалгаар мэргэшсэн ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.4.2. Төслийн бүтээн байгуулалт, туршилт тохиргоо, зүгшрүүлэлтийн ажил, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээгээр зайлшгүй ажиллах шаардлагатай гадаад, дотоод ажиллагсдын хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

4.5.1. Жилд 1 удаа "Нээлттэй хаалганы өдөр", "Ажил мэргэжил сурталчлах өдөрлөг" зохион байгуулж Өмнөговь аймгаас нийт ажилчдын 10%-с доошгүй хувийг бүрдүүлэхээр эрмэлзэж ажиллана.

4.5.2. Мандал-Овоо сумын харьяат уул уурхайн мэргэжлийн сургууль төгсөгчдийг уурхайн ажлын байранд дадлагад хамруулах, цаашлаад шаардлага хангасан төгсөгчдийг ажлын байраар хангаж ажиллана.

4.5.3. Жил бүр хичээл сурлагын амжилтыг нь үндэслэж малчин өрхийн их, дээд сургуулийн оюутан сурагчдад сургалтын төлбөрийн мөнгөн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтарч ажиллана.

Саус гоби сэндс ХХК-тай байгуулсан гэрээнд:

4.4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийт ажилтны 30 хүртэлх хувьд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах бодлогыг баримтлан ажиллана.

4.4.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нээлттэй ажлын байранд сонгон шалгаруулалт хийхдээ ажлын байрны шаардлага хангасан тохиолдолд орон нутгийн иргэдийг нэн тэргүүний ээлжид ажлын байраар хангаж ажиллахыг зорьж ажиллана.

4.4.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сургахад орон нутгийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажиллах бөгөөд шаардлагатай ажлын байр, тавигдах шаардлагыг тухай бүр олон нийтэд зарлана.

4.4.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нарийн мэргэжлийн инженер, техникийн ажиллагсдыг шаардлагатай тохиолдолд дотоод, гадаадын их дээд сургуульд өөрийн зардлаар сургаж мэргэшүүлж болно.

4.4.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн болон сум орон нутагт хэрэгцээт мэргэжлээр оюутны тэтгэлэгт хөтөлбөр зарлагдаж, тухайн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хангасан Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулиудад бакалаврын түвшинд суралцаж буй Гурвантэс, Сэврэй, Ноён, Баяндалай сумын оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.

4.4.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сумын иргэдэд мэргэжил олгох, шаардлагатай ур чадвар, мэдлэг, практик туршлага эзэмшүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн болон сумын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.

4.4.7 Сумын хүүхэд залуучуудын Босоо Монгол бичгийн чадвар, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор орон нутагтай хамтран ажиллах ба энэ чиглэлээр дэмжлэг үзүүлнэ. 4.4.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сумын иргэдэд мэргэжил олгох, шаардлагатай ур чадвар, мэдлэг, практик туршлага эзэмшүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сумын ЗДТГ-тай хамтран ажиллана. 4.4.9 Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, үндэсний болон бусад мэргэжлийн спортыг хөгжүүлэх зорилгоор орон нутагт дэмжлэг үзүүлнэ. 4.4.10 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Нарийн сухайтын уурхайн ажиллагсдыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамруулна.
Энержи ресурс ХХК-тай байгуулсан гэрээнд: 4.5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийт ажиллагсдын 50-иас доошгүй хувийг орон нутгийн харьяат иргэдийг ажиллуулах 4.5.2. Ажиллах хүч сонгох болон бараа, ажил, үйлчилгээг сонгохдоо холбогдох шаардлага, шалгуурыг хангасан орон нутагт бүртгэлтэй, татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд давуу эрх олгох 4.5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санал болгосон ажлын байр болон орон нутгаас худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг тухай бүр орон нутгийн иргэд, аж ахуй нэгжүүдэд нээлттэй зарлах 4.5.4. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах 4.6.1. Ажлын байр - Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлд нэн тэргүүний ач холбогдол өгөх - Тэднийг боломжит чиглэлүүдэд сургаж, дадлагажуулах замаар ажлын байр санал болгох - Орон нутагт шилжиж суурьшсан ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

2.2. Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр Мандал ресурс ХХК 5, "Саус гоби сэндс" ХХК 10, "Энержи ресурс" ХХК 5 заалтыг тус тус тусгасан байна.

2.3. Компаниуд хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг тухайн жилийн дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргад хүргүүлэхээр заасны дагуу Энержи ресурс ХХК тайлант онд хэрэгжүүлсэн гэрээний биелэлтийн тайланг хүргүүлдэг байна.

2.4. Харин Саус гоби сэндс ХХК хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг аймгийн Засаг даргад ирүүлсэн тайлан байхгүй, нотлогдохгүй байна. Энэ нь гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

2.5. Мандал ресурс ХХК хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг ирүүлэх хугацаа болоогүй байна. Мөн компани үндсэн үйл ажиллагаагаа одоог хүртэл эхлээгүй байгаа нь гэрээний хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

2.6. Хамтын ажиллагааны гэрээнд талууд гэрээний биелэлтийг хагас жил болон жилийн эцсийн байдлаар дүгнэж, тайланг дараа оны эхний улиралд багтаан аймаг, сумын ИТХ-д хүргүүлэхээр заасан байна.

2.7. Гэвч талууд гэрээний биелэлтийг хагас жил болон жилийн эцсийн байдлаар дүгнэсэн дүгнэлт байхгүй, аймгийн ИТХ-д хүргүүлсэн тайлан байхгүй байна. Энэ нь аймгийн Засаг дарга хамтын ажиллагааны гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байгаатай холбоотой байна.

2.8. Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байж гэрээнд заасан заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад өглөө.

2.2 Хамтын ажиллагааны хороо гэрээний биелэлтэд хяналт тавих үндсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

2.9. "Энержи ресурс" ХХК, "Саус гоби сэндс" ХХК-уудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах "Хамтын ажиллагааны хороо"-г аймгийн Засаг дарга байгуулахаар заасан байна.

2.10. Тус хороо нь талуудын тэгш оролцоог хангасан нутгийн захиргаа, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон орон нутгийн иргэдийн төлөөлөл болох 9 хүний бүрэлдэхүүнтэй байхаар тусгажээ.

2.11. Хамтын ажиллагааны хороонууд гэрээнд заасны дагуу гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний хэрэгжилтийг дүгнэж талуудад санал, зөвлөмж өгөх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

2.12. Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий "Хамтын ажиллагааны хороо"-ны зарим гишүүдийн ажлын байр өөрчлөгдсөн байгаа ч 2017 оноос хойш шинэчлэн байгуулаагүй байна.

2.13. Шинэчлэн байгуулаагүйн улмаас хорооны үйл ажиллагаа алдагдаж хамтын ажиллагааны гэрээний үр дүнг бууруулсан байна. Иймд хамтын ажиллагааны хороог шинэчлэн байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад өглөө.

2.14. "Мандал ресурс" ХХК-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд хамтын ажиллагааны хороо байгуулах, гэрээнд хяналт хийхтэй холбоотой заалтуудыг тусгаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хамтын ажиллагааны гэрээнд Саус гоби сэндс ХХК “Нийт ажилтны 30 хүртэлх хувьд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах бодлогыг баримтлан ажиллана”, “Мандал ресурс” ХХК “Нийт ажилчдын 10%-с доошгүй хувийг бүрдүүлэхээр эрмэлзэж ажиллана” гэж ИТХ-ын тогтоолд заасан хувь хэмжээг бууруулсан байна.
- Мандал ресурс” ХХК, “Саус гоби сэндс” ХХК-уудтай байгуулсан гэрээг аймгийн цахим хуудсаар мэдээлээгүй байна.
- Талууд гэрээний биелэлтийг хагас жил болон жилийн эцсийн байдлаар дүгнэсэн дүгнэлт байхгүй, аймгийн ИТХ-д хүргүүлсэн тайлан байхгүй байна.
- “Хамтын ажиллагааны хороо”-ны зарим гишүүдийн ажлын байр өөрчлөгдсөн байгаа ч 2017 оноос хойш шинэчлэн байгуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын орлогч Ц.Дэнээдорж танаа:

1. "Мандал ресурс" ХХК, "Саусгоби Сэндс" ХХК, "Энержи ресурс" ХХК-уудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнүүдийг Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-ны загвар, аймгийн ИТХ-ын 2016 оны 89 дүгээр тогтоолтой нийцүүлэн боловсруулж батлуулах.
2. "Саусгоби Сэндс" ХХК, "Энержи ресурс" ХХК-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий "Хамтын ажиллагааны хороо"-г шинэчлэн байгуулах.
3. Хамтын ажиллагааны хорооны хяналт тавих чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулах.
4. Талууд гэрээний биелэлтийг хагас жил болон жилийн эцсийн байдлаар дүгнэж, тайланг дараа оны эхний улиралд багтаан аймаг, сумын ИТХ-д хүргүүлж байх.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/34

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 10.1 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Зарим уул уурхайн компаниудын аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний орон нутгийн ажилтнуудын нийгмийн баталгаатай холбоотой заалтуудын хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивыг нэгж болгон хүлээлгэн өгөх, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Шижирболд)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

016010110

